

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын
11-ний өдрийн 255 дугаар тогтоолоор баталсан
“Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт
“Үнэт цаас гаргагчийн хугацаат тайлагнал болон тухай бүр
мэдээлэх мэдээллийн агуулга, хэлбэр”-ийн Жилийн
үйл ажиллагааны тайлагнал маягт 1

Жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 1/				
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.				
Тайлагнах хугацаа		2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр		
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар		Нэр: Хүннү Менежмент ХК УБГД: 9010001082 ҮЦК: HBZ Утас: +976 99079986		
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр		Монголын Хөрөнгийн Бирж		
Бизнесийн үйл ажиллагааны салбар		Санхүүгийн бусад үйл ажиллагаа		
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо		Мишээл Од Аудит ХХК		
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг		51,802 (тавин нэгэн мянга найман зуун хоёр) ширхэг		
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр		Бэлтгэсэн: Гүйцэтгэх захирал: Ц.Билэгсайхан Хянасан: Гүйцэтгэх захирал: Ц.Билэгсайхан		
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/			
Санхүүгийн байдлын үзүүлэлт	Үзүүлэлт (мянган төгрөг)	Эхний үлдэгдэл (1-р сарын 1)	Эцсийн үлдэгдэл (12-р сарын 31)	
	Хөрөнгө			
	Эргэлтийн хөрөнгө	40,022,000.0	40,022,000.0	
	Эргэлтийн бус хөрөнгө	10,100,000.0	10,100,000.0	
	Нийт хөрөнгө	50,122,000.0	50,122,000.0	
	Өр төлбөр ба эздийн өмч			
	Өр төлбөрийн нийт дүн	24,562,670.0	24,562,670.0	

		Эздийн өмч	25,559,330.0	25,559,330.0
		Нийт өр төлбөр ба эздийн өмч	50,122,000.0	50,122,000.0
		Үзүүлэлт (мянган төгрөг)	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
		Борлуулалтын орлого	0	0
		Борлуулалтын зардал	0	0
		Нийт ашиг (алдагдал)	0	0
		Борлуулалт, маркетингийн зардал	13,977,770.0	
		Санхүүгийн зардал	3,000.0	
		Үндсэн бус үйл ажиллагааны орлого	0	0
		Үндсэн бус үйл ажиллагааны зардал	0	0
		Татварын өмнөх ашиг	(13,980,770.0)	0
		Орлогын татварын зардал	0	0
		Цэвэр ашиг	(13,980,770.0)	0
	<i>Орлогын тайлан</i>			
1.1.	<i>Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт</i>			
	Аудитын компаниас зөрчилгүй дүгнэлт өгсөн			
1.2.	<i>Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/</i>			



ХҮННҮ МЕНЕЖМЕНТ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК

Нягтлан бодох бүртгэл-Аудит, Баталгаажуулалт, Аутсорсингийн
үйтчилгээ, Бизнесийн зөвлөгөө өгөх

2026.04.24 № А/43

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн Тайлангийн Аудитын Талаарх Тайлан

Бид 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн Хүннү менежмент ХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Зөрчилгүй санал дүгнэлт

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт /АОУСИ-уудын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тайлбарласан. Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЕЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу Бид байгууллагаас хараат бус бөгөөд хууль болон НБЕЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн.

Аудитаар Хүннү менежмент ХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно. **Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага**

Хүннү менежмент ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон санхүүгийн тайлангийн аудит

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг

бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэдэг. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудыг баримталж, санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаар үл үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай материаллагт тооцогддог.

Санхүүгийн тайлагналыг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцооллуудын үндэслэлтэй байдал, хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан.

Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж бид итгэж байна.

Бусад асуудал

Энэхүү аудиторын дүгнэлт нь зөвхөн ТрансКонтейнер Монгол ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан бөгөөд бусад этгээд ашиглах ёсгүй. Энэхүү тайлангийн хүрээнд бид гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй.

Хүндэтгэсэн:

МИШЭЭЛ ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Мэргэшсэн нягтлан бодогчид



О.ОДОНЧИМЭГ

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 хороо, 2 хороотой Баянхайрхан, өргөн тээвэр Эргэн цэнгэр 703 тоот
Вэб хуудас: www.mishaelodaudit.mn И-мэйл: Mishaelodaudit@mn Утас: +976 70159029, 99069029, 99065204.

2

Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, уридлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан мэдээлэл

2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Үйл ажиллагааны ашгийн хувь	0%
		Цэвэр ашгийн хувь	0%
		Өөрийн хөрөнгийн өгөөж	0%
		Нийт хөрөнгийн өгөөж	0%
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	-	
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	2025 онд Хүннү Менежмент ХК үйл ажиллагаа эрхлээгүй болно.	
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Тайлант хугацаанд тайлангийн гадуур бүртгэсэн ажил гүйлгээ гараагүй болно.	
2.5.	Тайлан хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	Тайлант хугацаанд зээл аваагүй болно.	
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлан хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/		
	Тайлант сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй болно.		
4.	Цалин урамшууллын мэдээлэл		
	2025 онд үйл ажиллагаа эрхлээгүй болно.		
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл		
	Засаглалын бүтэц, үйл ажиллагаа Хүннү Менежмент/ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд түүний чөлөөт цагт компанийн үйл ажиллагааг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилогдсон Төлөөлөн Удирдах Зөвлөл удирдана. Хүннү Менежмент ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 6 ердийн гишүүн 3 хараат бус гишүүний бүрэлдэхүүнтэй сонгогдсон ба Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн Гүйцэтгэх захирал, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга, томилогдсон ажилладаг. Гүйцэтгэх захирал нь компанийн удирдлагын чиг үүрэг, өдөр дутмын үйл ажиллагаанд хяналт тавих, ТУЗ-өөс өгсөн үүрэг даалгаврын биелэлт, стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилладаг.		
6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл		
	-		

7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/																				
		<table border="1"> <thead> <tr> <th>Хувьцаа эзэмшигч</th> <th>Хувьцааны тоо</th> <th>Эзэмшлийн хувь</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Ц.Билэгсайхан</td> <td>17,776</td> <td>34.32%</td> </tr> <tr> <td>Г.Хүслэн</td> <td>8,843</td> <td>17.07%</td> </tr> <tr> <td>Б.Баасансүх</td> <td>5,442</td> <td>10.51%</td> </tr> <tr> <td>С.Эрдэм</td> <td>3,138</td> <td>6.06%</td> </tr> <tr> <td>Бусад</td> <td>51,802</td> <td>100%</td> </tr> </tbody> </table>	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Эзэмшлийн хувь	Ц.Билэгсайхан	17,776	34.32%	Г.Хүслэн	8,843	17.07%	Б.Баасансүх	5,442	10.51%	С.Эрдэм	3,138	6.06%	Бусад	51,802	100%	
Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Эзэмшлийн хувь																			
Ц.Билэгсайхан	17,776	34.32%																			
Г.Хүслэн	8,843	17.07%																			
Б.Баасансүх	5,442	10.51%																			
С.Эрдэм	3,138	6.06%																			
Бусад	51,802	100%																			
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл																				
	Төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд хувьцаа санал болгоогүй болно.																				
9.	Ногдол ашгийн мэдээлэл																				
	Хүннү Менежмент ХК нь 2025 онд үйл ажиллагаа эрхлээгүй тул Ногдол ашиг олгоогүй болно.																				
10.	Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл																				
	Тайлант хугацаанд олон нийтийн нийгмийн хариуцлагын хүрээнд үйл ажиллагаа эрхлээгүй байна.																				
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:																					
Гүйцэтгэх захирал Ц.Билэгсайхан 																					
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:																					
Овог, нэр: Ц.Билэгсайхан Албан тушаал: Гүйцэтгэх захирал Гарын үсэг:																					